



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



МУИС-ИЙН  
ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ,  
ЭДИЙН ЗАСГИЙН  
ОНОЛЫН ТЭНХИМ

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын  
Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

**ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ БА  
НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, ЯДУУРАЛ**



2009 оны хоёрдугаар хагас жилийн тайлан

Улаанбаатар хот



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

**Тайланг бэлтгэсэн:** МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн  
Эдийн засгийн онолын тэнхимийн судлаачдын баг

**С.ДАВААСҮРЭН**

судлаач, АНУ-ын Өмнөд Нью-Хемпширийн Их Сургуулийн докторант

**Б.ОТГОНТӨГС**

судлаач, АНУ-ын Колумбын Их Сургуулийн докторант

**Б.СУВД**

судлаач, МУИС-ийн тэргүүлэх профессор, доктор

© Нээлттэй Нийгэм Форум


Нээлттэй Нийгэм Форумын санаачилга болон санхүүжилтээр  
энэхүү тайланг бэлтгэв.

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Энэхүү судалгаагаар гаргасан үнэлэлт, дүгнэлт нь уг судалгааг хийж  
гүйцэтгэсэн судлаачдын байр суурийг илэрхийлнэ.

DDC  
331'517  
Х-557

ISBN: 978-99929-74-49-4



## АГУУЛГА

1. Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал	4
1.1 Ажил эрхлэлт	4
1.2 Ажилгүйдэл	7
1.3 Албан бус секторын ажил эрхлэлт	12
2. Нийгмийн эмзэг байдал	13
2.1. Эдийн засгийн хямрал: Нийгмийн эмзэг байдал ба ядуурал	13
2.2. Нийгмийн эмзэг байдал, ядуурал ба бэлэн мөнгөний тусламж	21
Дүгнэлт	26
Ашигласан материал	28
Хавсралт. 1	30



# 1. МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Манай орны хөдөлмөрийн зах зээл дээр хямралын улмаас гарсан өөрчлөлтийн талаарх энэ судалгаанд албан ба албан бус секторын ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин болон хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн шалтгааныг авч үзлээ. Түүнчлэн ажилгүйдлийг бууруулах чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын талаар албан ёсны статистик тоон мэдээлэл болон

Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газар, Нээлттэй Нийгэм Форумгаас хийсэн түүвэр судалгаанууд дээр үндэслэн шинжилж, дүгнэлт гаргалаа.

## 1.1 Ажил эрхлэлт

ҮСГ-аас хэрэгжүүлдэг “Ажиллах хүчний судалгаа”-гаар манай улсын эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 2009 оны 11 дүгээр сарын байдлаар 6.6 хувиар өслөө. Улсын эдийн засгийн идэвхитэй хүн амын өсөлт нь нийт ажил эрхэлж байгаа болон ажил хайж байгаа хүмүүсийн тоонд өөрчлөлт орсныг харуулахаас бус хүн амын өсөлт биш юм.

Зураг 1. Нийт ажиллагсдын тоо (мянган хүн)<sup>1</sup>



Эх сурвалж: Олон улсын хөдөлмөрийн газрын мэдээ болон ҮСХ. Статистикийн мэдээлэл. 2009. 11 дүгээр сар.


1 2009 оны 9 сарын байдлаар.



Зураг 1- ээс харахад 2008 оны сүүлээр эдийн засгийн идэвхитэй хүн амын 97.2 хувь буюу 1,041,700 нь ажил эрхэлж буй хүмүүс, 29,800 буюу 2.8 хувь нь бүртгэлтэй ажилгүйчүүд байсан. Тэгвэл 2009 оны 9 дүгээр сард эдийн засгийн идэвхитэй хүн ам 1,137,100 байгаагаас 89.5 хувь буюу 1,018,100 нь ажил эрхэлж буй хүмүүс, 119,000 буюу 10.5 хувь нь ажилгүйчүүд буюу ажилгүйдлийн албан ёсны түвшин 10.5 хувь болж өссөн байна.<sup>2</sup> Тиймээс өмнөх онтой харьцуулахад манай улсын эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 6.6 хувиар өссөн нь нийт ажиллагсдын тоо өссөн биш, харин ажилгүйчүүдийн тоо өссөнтэй холбоотой байна.<sup>3</sup>

2009 оны 11 дүгээр сарын байдлаар ажил эрхэлж байгаа нийт хүн амын 52 хувь нь эрэгтэйчүүд, 48 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 2009 оны сүүлээр эмэгтэй ажил эрхлэгчдийн тоо буурсан (Зураг 2). Байршлын хувьд хот, хөдөө дэх ажиллагсдын хувь хэмжээ ижил 50 хувь байна. 2008 оны байдлаар хөдөлмөрийн насны мөртлөө ажил эрхэлдэггүй, хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст ажил хайж байна гэж бүртгүүлээгүй учраас эдийн засгийн идэвхитэй хүн амд буюу ажиллах хүчинд ороогүй 617,200 хүн байсан бол 2009 оны 11 дүгээр сарын байдлаар энэ тоо 708,600 болж 13 хувиар нэмэгдсэн байна.<sup>5</sup>

Зураг 2. Нийт ажиллагсдын тоо хүйсээр (мянган хүн)<sup>4</sup>



Эх сурвалж: Олон улсын хөдөлмөрийн газрын мэдээ болон ҮСХ. Статистикийн мэдээлэл. 2009 оны 11 дүгээр сар.

<sup>2</sup> ҮСГ. Статистикийн мэдээлэл. 2009. 5 дугаар сар.

<sup>3</sup> Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоонд сүүлийн долоо хоногт ажил хийсэн болон ажилгүй боловч ажил идэвхитэй хайж байгаа хүмүүс орно.

<sup>4</sup> 2009 оны 9 сарын байдлаар.

<sup>5</sup> Эдгээрийн ихэнх хувийг их, дээд сургууль, коллеж, техник мэргэжлийн анхан болон дунд сургууль, төвүүдэд суралцаж байгаа оюутнууд, гэрийн ажилтай, хүүхэд асардаг, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хугацаат цэргийн алба хааж байгаа, ял эдэлж байгаа хүмүүс эзэлж байгаа боловч энд мөн ажилгүй боловч ажил хайдаггүй, ажил хайдаг бол албан ёсоор ажил хайж байна хэмээн бүртгүүлээгүй хүмүүс ордог.




2008 оны сүүлээр ажил эрхэлж байгаа хүмүүсийн 36.2 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 18.3 хувь нь аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт, 45.5 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байсан бол 2009 оны 11 дүгээр сарын байдлаар 35 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 17 хувь нь аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт, 47.8 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байна. Үүнээс харахад, аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт ажиллагсдын хувь хэмжээ буурсан ба үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо өссөн байна.

ҮСГ-аас нийт ажиллагсдын тоог сар, улирлаар гаргадаггүй зөвхөн аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоог мэдээлдэг тул жилийн хугацаанд нийт ажил эрхлэлтийн динамик өөрчлөлтийг харуулах боломжгүй байна. Гэхдээ 2009 оны 11 сарын түвшинг 2008 оны мөн үеийнхтэй харьцуулахад боловсруулах аж үйлдвэрт болон

цахилгаан, дулаан, усан хангамжийн салбарт ажиллагсдын тоо хэвэндээ харин уул уурхай, олборлох салбарт ажиллагсдын тоо 5.4 хувиар буурсан мэдээ байна. Уул уурхай, олборлох салбар дотроо ашигт малтмал олборлолт эрхэлдэг ажиллагсдын тоо илүү буурсан нь эдийн засгийн хямрал нөлөөлсөөр байгааг харуулж байна.

Цалингийн хувьд эдийн засгийн хямралаас өмнөх хоёр жилд улсын хэмжээнд сарын дундаж цалингийн түвшин эрс өссөн байсныг Зураг 3-аас харж байна. 2009 он гараад албан секторт цалингийн түвшин хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар статистик мэдээ байхгүй байгаа боловч албан бус секторт сарын орлогын түвшин эрс өөрчлөлттэй байгаа талаар Дэлхийн Банкнаас мэдээлж байна. Монгол дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газраас 2009 оны 12 дугаар сард хийсэн түүвэр судалгааын дүн нийслэл

**Зураг 3. Сарын дундаж цалингийн түвшин улсын хэмжээнд (мянган төгрөгөөр)**



Эх үүсвэр: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Laborstat тоо баримт. [www.ilo.org](http://www.ilo.org)



дэх захууд, төмөр зам болон ачаа тээврийн компаниудын ачааг ачиж зөөж цалинждаг ажиллагсдын сарын дундаж цалин 2009 оны 4 дүгээр сарын байдалтай харьцуулахад харилцан адилгүй өөрчлөгдсөнийг харуулж байна.

### Хүснэгт 1. Нийслэл дэх албан бус секторт ажиллагсдын сарын дундаж орлогын өөрчлөлт (мянган төгрөгөөр)<sup>6</sup>

	2009.4	2009.9	2009.12
Гурвалжингийн гүүр	90-210	120-150	90-150
Ачаа тээврийн компаниудын ачаа ачих	240	240-270	180-210
Амгалан дахь Ботаникийн цемент ачих буулгах	240-900	81-87	мэдэх боломжгүй
Барс зах	150-300	180-300	300-450
Нарантуул зах	150-180	210-240	240-300
100 айлын барилгын материалын зах	150-300	300-450	150-300

Эх сурвалж: Монгол дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын тайлан. [www.worldbank.org.mn](http://www.worldbank.org.mn)

Хүснэгт 1-ээс харахад 2009 оны 12 дугаар сар гэхэд аж үйлдвэрлэл ялангуяа барилгын салбарын уналтын улмаас аж үйлдвэрлэлийн ачаа бараа зөөдөг ажиллагсдын орлого буурч, үйлчилгээний газрууд, өрхийн хэрэглээг хангадаг захууд дээр ажилладаг ажиллагсдын орлого нэмэгдсэн байдал ажиглагдаж байна.

## 1.2 Ажилгүйдэл


2009 он гараад Монголын хөдөлмөрийн зах зээл дээр бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өсөх, ашигт малтмал олборлолтын салбарт ажилгүйдэл нэмэгдэх, албан ёсны секторт шинээр ажилд авах нь зогсонги байдалд орох, гадаад улс орон дахь эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан ажиллах хүчний гадаад руу шилжих хөдөлгөөн буурах, ажиллагсад гадаадаас буцаж ирэх, гадаадад ажиллагсдаас ирэх мөнгөн гуйвуулгын хэмжээ багасах байдлаар хямралын нөлөө илэрч байна.

Манай улсад дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нөлөөлж эхлэхээс өмнөх 2-3 жилд бүртгэлтэй ажилгүй хүмүүсийн хувьд тооцдог ажилгүйдлийн түвшин бага буюу 3.2-3.5 хувь гэж үзэж байсан. Харин ҮСХ-ноос 2008 оны 7-9 дүгээр сарын хооронд хийсэн “Ажиллах хүчний судалгаа”-гаар эдийн засгийн хямрал эхлэхээс өмнө нийт улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8 хувь орчим байсан байна. Хямрал эхэлсэн 2009 онд уг түвшин өсч гуравдугаар улирал гэхэд 10.5 хувь болсон байгааг Зураг 4-т харууллаа.

ҮСХ-оос гаргадаг сар тутмын мэдээллээр хямрал эхэлж байсан 2008 оны 12 дугаар сард дүүрэг, хороо, сумын хөдөлмөр эрхлэлтийн албанд улсын хэмжээнд нийт 29,813 хүн ажилгүй, ажил хайж байна гэж бүртгүүлж байсан бол 2009 он гараад эхний улиралд энэ тоо 34,753, хоёрдугаар улиралд 39,495, гуравдугаар улиралд 40,354 болж, дөрөвдүгээр улиралд аажмаар буурч 39,777 хүрсэн байна.

<sup>6</sup> Сарын дундаж орлогыг харуулах үүднээс өдрийн орлогын хэмжээг 30 хоноогоор үржүүлж гаргалаа.

Зураг 4. Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: ҮСХ. 2008. Статистикийн эмхтгэл. ҮСХ. 2009 оны 11 сарын мэдээлэл



Зураг 5-аас харахад 2009 оны 11 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны 12 дугаар сарынхтай харьцуулахад 33 хувиар их байна. Мөн дөрөвдүгээр улиралд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо гуравдугаар улиралтай харьцуулахад буурсан боловч хямралын өмнөх үеэс даруй 10,000 хүнээр их байна.


ҮСХ-ноос 2009 оны 7-9 дүгээр сарын хооронд хийсэн "Ажиллах хүчний судалгаа"-гаар улсын хэмжээгээр ажилгүйчүүдийн түвшин 10.5 хувь гэж гарсан талаар дурдсан. Энэ тоо бодитой болохыг дараах судалгаа харуулж байна. Үүнд 2009 оны 4 дүгээр сард Нээлттэй Нийгэм Форумаас санхүүжүүлж Улаанбаатар хотын 1,000 өрхөөс авсан "Хэрэглэгчийн итгэлийн индекс" тооцох түүвэр судалгаагаар нийслэл

Зураг 5. Бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо, улсын хэмжээнд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. 2009. Сарын статистикийн мэдээлэл.






хотод ажилгүйдлийн түвшин 10 хувь гэсэн тооцоо гарч байсан бол 11 дүгээр сард давтан хийсэн түүвэр судалгаагаар уг түвшин буурч 6.7 хувь болсон байна. Энэ нь Улаанбаатар хотод судалгаанд оролцсон ажилгүй, ажил идэвхитэй хайж хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн болон бүртгүүлээгүй боловч ажил хайж буй хүмүүсийн тоог нийт судалгаанд оролцсон эдийн засгийн идэвхитэй хүн амд харьцуулж гаргасан үзүүлэлт юм. Зураг 6-гаас харахад нийслэл хотод ажилгүйдлийн түвшин 3.3 пунктээр буурсан нь хөдөлмөрийн зах зээлийн байдал аажмаар сайжирч байгааг харуулж байна.

2009 оны 4 дүгээр сард нийслэл дэх эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байсан бол 11

дүгээр сард мөн адил өндөр байна. Гэхдээ 2009 оны 11 дүгээр сарын байдлаар нийслэл дэх эмэгтэйчүүдийн ажилгүйдэл эрэгтэйчүүдийнхээс илүү буурсан байгаа нь Зураг 6-гаас харагдаж байна. Эхний удаагийн түүвэр судалгаагаар эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин 11.5 хувь, эрэгтэйчүүдийнх 8.6 хувь байсан бол 11 сард хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.5 хувь, эрэгтэйчүүдийнх 6.0 хувь болж буурсан байна. Ажиллах хүчний 50 хувь нь нийслэлд амьдарч байгаа ба ажилгүйдлийн түвшин аажмаар буурч байгаа нь эхний хагас жилд хийсэн тайланд тэмдэглэснээр хямрал хөдөлмөрийн зах зээлд нийтэд нь шууд их хэмжээний сөрөг нөлөө хараахан үзүүлээгүй байгааг дахин харуулж байна.


**Зураг 6. Улаанбаатар хот дахь ажилгүйдлийн түвшин, хүйсээр**



Эх сурвалж: Нээлтэй Нийгэм Форум. "Хэрэглэгчийн итгэлийн индекс" тооцох түүвэр судалгааны тайлан. 2009 оны 11 дүгээр сар.



Зураг 7. Бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо, байршлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. 2009. 11 дүгээр сарын статистикийн мэдээлэл.

Аймгуудын хувьд 2009 оны 11 дүгээр сарын байдлаар нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 31,125 болсон нь 2008 оны 12 дугаар сарын байдлаас 32.8 хувиар нэмэгдсэн байна. Зураг 7-оос харахад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо хамгийн их өссөн аймгуудын тоонд Булган (861

хувь), Төв (135 хувь), Говьсүмбэр (94 хувь), Увс (74 хувь), Өмнөговь (73 хувь), Ховд (59 хувь) орж байна. 2009 оны 11 дүгээр сарын байдлаар нийслэлд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,033 хүнээр буюу 32 хувиар нэмэгдсэн байна.

### Шигтгээ: Дэлхийн ажилгүйдлийн чиг хандлага

2009 оны 3 дугаар сард Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын урьдчилсан тооцоогоор дэлхий нийтийн хэмжээгээр хямралын улмаас 2009 оны сүүлээр дор хаяж 20 сая хүн ихэвчлэн барилга, санхүү, үл хөдлөх хөрөнгийн болон автомашин үйлдвэрлэлийн салбарт ажилгүй болж ажилгүйчүүдийн эгнээнд шинээр шилжинэ гэж тооцож байсан. Гэхдээ энэ үзэгдэл бүс нутгуудын хувьд харилцан адилгүй байна. Уг хямрал эхэлсэн АНУ-д ажилгүйдлийн түвшин 9.4 хувь, Канадад 8.0 хувь, Францад 8.8 хувь, Германд 6.9 хувь, Японд 5.5 хувь, Хятадад 5.2 хувь, Өмнөд Солонгост 3.3 хувь байгаа бол Ирландад 11.9 хувь, Латвид 18.4 хувь, Испанид 17.9 хувь, Туркд 13.4 хувь болж эрс өссөн байна. Дэлхийн хөдөлмөрийн зах зээл дээр гарч байгаа гол өөрчлөлтүүд сургууль төгсөөд шинээр хөдөлмөрийн зах зээл дээр гарч байгаа залуучууд, орон тооны бус түр ажилчид, эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусч байна.

Эх сурвалж: Олон улсын хөдөлмөрийн байгууллага ба Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тоо мэдээ.



Хүснэгт 2 болон Зураг 8-аас хөдөлмөрийн нийлүүлэлтийг харахад хөдөлмөр нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажилгүй хэмээн шинээр бүртгүүлсэн хүмүүсийн тоо хоёр, дөрөв, таван сард өндөр байсан байна. Дөрөв, тавдугаар саруудад ажилгүй хэмээн шинээр бүртгүүлсэн хүмүүсийн тоо ихэссэн нь хямралын

нөлөө гэхээсээ илүү их дээд болон тусгай дунд мэргэжлийн сургуулийг төгсөгчид хөдөлмөрийн зах зээл рүү шинээр орж ирсэнтэй холбоотой юм.


Зураг 8-аас харахад нийт бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хүний тоо 5 ба 10 дугаар сард хамгийн өндөр байсан. 10 дугаар

## Хүснэгт 2. 2009 онд шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд орсон хүний тоо

	11	22	33	44	55	66	77	88	99	110
Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо	44,033	77,938	33,012	77,187	99,000	44,930	44,635	44,635	55,328	66,057
Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хүний тоо	11,806	33,845	11,802	33,712	55,760	33,118	33,338	33,768	44,300	44,854
Ажилд орсон хүний тоог шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдтэй харьцуулахад (%)	444.7	448.4	559.8	551.6	664	663	772	881.2	880.7	880.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. 2009. Статистикийн сарын мэдээлэл.

## Зураг 8. 2009 оны хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд





сард шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо болон эдгээрээс ажилд орсон хүний тоо тус тус өссөн байна.

Өөрөөр хэлбэл, шинээр ажилгүй болсон, ажил хайж байгаа хүмүүсийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр бүртгүүлсэн ажилгүй хүмүүсээс ажилд орсон хүний тоо ч нэмэгдэх хандлагатай байна.

2009 оны 5 дугаар сарын байдлаар ажил хайгсдыг боловсролын түвшнээр нь авч үзэхэд 71,5 хувь нь дээд, тусгай дунд, мэргэжлийн анхан шатны болон бүрэн дунд боловсролтой, харин 24.1 хувь нь бүрэн бус дунд, 3.6 хувь бага боловсролтой, зөвхөн 0.4 хувь нь боловсролгүй байна. 2009 оны 11 дүгээр сарын байдлаар мөн адил ажилгүй хэмээн бүртгүүлсэн нийт 39,755 хүний 71.4 хувь нь дээд, тусгай дунд, мэргэжлийн анхан шатны болон бүрэн дунд боловсролтой, харин 24.7 хувь нь бүрэн бус дунд, 3.1 хувь нь бага боловсролтой, зөвхөн 0.4 хувь нь боловсролгүй байна. Ихэнх хөгжиж буй орнуудад ажилгүй хүмүүс доогуур боловсролтой буюу боловсролгүй байдаг бол Монгол Улсад боловсролын түвшин ахих тусам ажилгүй байх магадлал өндөр байна. Өөрөөр хэлбэл, хямралын үед дээд болон бүрэн дунд боловсролтой хүн болгон ажилтай байж чадахгүй байна.

### 1.3 Албан бус секторын ажил эрхлэлт

Эдийн засгийн хямралын үед албан сектор дахь ажил эрхлэлт буурч, албан бус сектор дахь ажил эрхлэлт нэмэгддэг. Урьд нь хийгдэж байсан удаа дараагийн судалгааны дүгнэлтүүдээс харахад, албан бус сектор манай орны нийт ажиллах хүчний 30-35 хувь ажилладаг байна. Хямралын

улмаас албан бус секторт ажиллагсдын тоо өссөн байх магадлалтай. Гэвч эдгээр хүмүүсийн тоог албан ёсоор тооцож гаргадаггүй. 2009 он гарсаар нийслэл хотод албан бус секторт ажиллагсдын талаар Дэлхийн Банкнаас хийсэн судалгаанууд зарим бодит мэдээллийг өгч байна. Үүнд 2009 оны 12 дугаар сард Дэлхийн Банкнаас нийслэл дэх хүнсний болон барааны захууд, төмөр замын буудал болон Гурвалжингийн гүүрийн дэргэд өдрөөр ажилладаг хүмүүсийн тоо, тэдний орлого, ажлын ачааллын талаар хийсэн түүвэр судалгаагаар эдгээр албан бус секторт ажиллаж байгаа хүмүүсийн тоо 2009 оны 4 дүгээр сард нийтдээ 1255, 9 дүгээр сард 1570 байсан бол 12 дугаар сард нийт 1200 болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, 2009 оны гуравдугаар улиралд энэ төрлийн хөдөлмөрийн эрэлт хэрэгцээ өндөр байсан бол дөрөвдүгээр улиралд багассан байна. Энэ нь өвлийн улиралд барилгын салбарын үйлдвэрлэл зогсдогтой холбоотой. 12 дугаар сар гэхэд нийслэл дэх хүнсний болон барааны захууд, төмөр замын буудал болон Гурвалжингийн гүүрийн дэргэд өдрөөр ачаа зөөж, ачиж, буулгаж ажилладаг хүмүүсийн тоо 9 дүгээр сартай харьцуулахад 24 хувиар буурсан ба тэдний бодит цалин дунджаар 60 хувь буурсан гэсэн тооцоо гарсан байна. Тиймээс албан бус секторт ажилгүйдэл улирлын чанартай нэмэгдэж байна.

## 2. НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ

### 2.1. Эдийн засгийн хямрал: Нийгмийн эмзэг байдал ба ядуурал

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал доод цэгтээ хүрч улмаар тогтворжих зарим шинж тэмдэг ажиглагдаж эхэлсэн, гэхдээ санхүүгийн тогтолцоонд хүндрэл үргэлжилсээр байгаа болон ажилгүйдэл, ядуурлын түвшин нэмэгдэж буй зэргээс шалтгаалан дэлхийн эдийн засгийн сэргэлт нь удаашрах төлөвтэй болохыг хямралын асуудлаар бичиж буй өмнөх тайлан<sup>7</sup>-даа тэмдэглэсэн билээ. Дэлхийн Банкнаас гаргасан судалгаагаар<sup>8</sup> санхүү эдийн засгийн хямрал нь манайх шиг хөгжиж буй эдийн засгуудад санхүү, бүтээгдэхүүн, хөдөлмөрийн зах зээл, мөнгөн гуйвуулга, шилжүүлгийн сувгаар дамжин сөрөг нөлөө үзүүлсэн. Түүнчлэн санхүүгийн зах зээлд бий болсон валютын ханш өөрчлөгдөх, зээлийн олдоц муудах, хадгаламж багасгах, биет хөрөнгийн үнэлгээ буурах зэргээс үүдэлтэй хүндрэл нь бүтээгдэхүүний зах зээлд үйлдвэрлэлийн хэмжээ, өсөлт буурахад нөлөөлсөн. Тэгвэл, хөдөлмөрийн зах зээл дэх ажил эрхлэлт багасч, ажилгүйдэл өсч, ажиллагсдын ашиг орлого буураад байгаа бол мөнгөн гуйвуулга, шилжүүлгийн хувьд гадаадад ажиллагсад гэр бүлдээ явуулдаг мөнгөн шилжүүлгийн хэмжээ эрс багасчээ. Тухайлбал, хөгжиж буй эдийн засаг руу чиглэсэн хувийн хөрөнгийн цэвэр урсгал энэ онд 165.0 тэрбум ам. доллар хүртэл буурч болзошгүй байгаа нь 2007 оны түвшний 17 хувьтай тэнцэх хэмжээ юм.

7 Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө, гуравдугаар улирлын тайлан, 2009 он

8 "Financial Crisis and the Developing Countries", World Bank, PREM-Report, 2009



Санхүү, бүтээгдэхүүн, хөдөлмөрийн зах зээлд бий болсон сөрөг хандлага нь нийгмийн үйлчилгээний зардал, нийгмийн чиглэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Учир нь дээрх зах зээлд хүндрэл үүссэнээр нийгмийн чиглэлийн үйлчилгээ, хөтөлбөрийн санхүүжилтийн томоохон хувийг эзэлдэг засгийн газрын орлого буурсан ба төсөвт дарамт учирснаар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зардлууд буурав. Үүний сацуу ажилгүйдлийн хэмжээ өссөнөөс ажилгүйдлийн тэтгэмжийн эрэлт эрс өсчээ. Өрх гэрийн хувьд бүтээгдэхүүн, хөдөлмөрийн зах зээлд бий болсон хүндрэлийн улмаас хэрэглээгээ танах, хэрэглээг шаардлагатай түвшинд хангахтай холбогдсон бэрхшээлтэй илүү ихээр тулгарах боллоо. Тухайлбал, хүүхдээ сургуульд суралцуулахад хүндрэл үүсэх, зайлшгүй хэрэглэх хүнсний хэрэглээний чанар, төрөл зүйл буурах, цаашилбал, хүүхдийнхээ эрүүл мэнд, хоол тэжээлийн зардлаа нөхөж чадахгүйд хүрснээс олон иргэд ядууралд нэрвэгдэж байна.

Хямралын томоохон сөрөг нөлөө нь хөгжингүй орнуудад ажилгүйдэл эрс нэмэгдэх, харин хөгжиж буй орнуудад ядуурлын түвшин огцом өсөх хандлагаар илрэв. Мянганы хөгжлийн зорилтын ядуурлын түвшинг хангах үйл явц хөгжиж буй орнуудад хямралын өмнө ч асуудалтай байсан бол хямралын нөлөөгөөр байдал улам муудах төлөвтэй байна. Ядуурал, нийгмийн эмзэг байдал нь харилцан хүчтэй хамааралтай байдаг. Нийгмийн эмзэг байдлыг биет болон нийгмийн хүчин зүйлийг оролцуулан тооцдог бөгөөд энэ утгаараа ядуурал нь эмзэг байдалд нөлөөлдөг хамгийн том, ноёрхогч хүчин зүйл болдог. Гэхдээ нийгмийн эмзэг байдлыг дан ганц ядуурлын түвшингээр тодорхойлох нь учир дутагдалтай.



Нийгмийн эмзэг байдал нь эдийн засаг, улс төр, соёлын болон институцийн хүчин зүйлсийн харилцан хамаарлыг харуулж, тэдгээрийн харилцан шүтэлцээг өөртөө багтаадаг. Тиймээс тус тайланд толилуулж буй нийгмийн эмзэг байдлын тухай ойлголт нь манай улсын Нийгмийн халамжийн хуульд заасан нийгмийн эмзэг бүлэг<sup>9</sup> гэдэг ойлголтоос илүү өргөн хүрээтэй болохыг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Нийгмийн эмзэг байдал нь тухайн улсын иргэдийн байгалийн ба нийгмийн баялгаас ашиглах, хүртэх эрх, улс төрийн эрх мэдэл болон улс төрийн төлөөлөлд оролцох оролцоо, соёл болон уламжлалын хүчин зүйлс, тодруулбал нас, хүйс, шашин шүтлэг болон тухайн нийгэмд үйлчилдэг бусад хэм хэмжээнээс хүчтэй хамаардаг.<sup>10</sup>

Эмзэг байдал нь олон талтай, зөвхөн эдийн засгийн шокуудтай холбоотой биш, экологийн байдал, байгалийн аюул гамшиг юмуу хүний үйл ажиллагаагаар хохирол учрах зэрэг үйл явдалтай холбоотой<sup>11</sup>. Дээрх тодорхойлолтуудаас авч үзвэл эмзэг байдал гэдэг нь олон хүчин зүйлээс хамааралтай бөгөөд аль нэг хүчин зүйлийн улмаас эсвэл байгалийн гэнэтийн өөрчлөлт, урьдчилан тооцож байгаагүй, хүлээлт үүсээгүй үеийн хүчтэй цочролын улмаас бий болох хүндрэл, өөрийн хүчээр даван туулах боломжгүй байдалд орохыг хэлнэ. Эмзэг байдал хэмээх ойлголтыг юунд хамааруулан хэрэглэж байгаагаас шалтгаалан янз бүрийн байдлаар тодорхойлж байна.

9 Монгол Улсын “Нийгмийн халамжийн тухай” хуульд заасан “тэжээн тэтгэх төрөл садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон ядуу, нэн ядуу амьдралтай олон хүүхэдтэй өрх толгойлсон эх / эцэг / -ийг “нийгмийн эмзэг бүлэг” гэнэ.

10 Weisner, B., P. Blaikie, T. Cannon and I. Davis (2004), *At Risk: Natural hazards, people's vulnerability and disasters* (2nd ed.), New York: Routledge.

11 Third Asia Development Forum 2001

Өрх, иргэний эмзэг байдлын түвшин гэдэг бол өнөөдөр ядуу юу үгүй юу гэдгээс үл хамааран ирээдүйд түүний хэрэглээ буурч ядуурч болох магадлал юм. Өөрөөр хэлбэл, эмзэг байдлыг эрсдлээр тодорхойлдог.

Эмзэг байдлыг бий болгоход нөлөөлж байгаа хүчин зүйлүүдээр түүнийг ангилан үзэж болно.

- **Эдийн засгийн нөхцөл байдлын** улмаас ажилгүй болох, зах зээлээс алслагдмал орчинд аж төрөх, худалдааны таатай бус нөхцлийн улмаас алдагдалд орох, үнийн тогтворгүй байдлаас хамаарч өр тавих, цалин тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь төлөхгүй байгаагаас шалтгаалан бэлэн мөнгөний дутагдалд орж амьдралаа залгуулж чадахгүйд хүрэх, үндсэн хөрөнгөө алдах болон өрөнд орох зэрэг нь өмнө нь ядуу биш байсан ч ядуурах гэнэтийн нөхцөл болдог.
- **Нийгмийн харилцаанаас** тусгаарлагдах, ураг төрлийн холбоо сулрах, тасрах, итгэл алдрах, бусадтай хамтран ажиллаж чадахгүй байх, орчиндоо дасч өөрийн байр сууриа олж чадахгүй байх (шинэ ажилтан, малчдын туршлагагүй байдал), нийгэмшээгүй буюу нийгмээрээ хэвшин тогтсон хэм хэмжээнд амьдарч чадахгүй болсон зэрэг нь эмзэг байдалд нөлөөлдөг.
- **Байгаль орчны зохисгүй нөлөөллийн** улмаас үүсэх эмзэг байдалд дэлхийн цаг уурын дулаарал, зуд, ган, үер, шороон болон элсэн, цасан шуурга, түймэр, хот суурин газрын агаарын бохирдол зэргийг тооцдог.
- **Эрүүл мэндийн хувьд** дэлхий нийтийг



хамарсан цар тахал, халдварт өвчин, хувь хүн биеэ зохистой авч явж чадаагүйн улмаас үүсэх эрсдэл, чанар муутай ундны ус, хүнсний бараа, эм, тариа, ариун цэвэр, эрүүл ахуй муудснаас болон биеэ үнэлснээс эрүүл мэнд эрсдэлд орох зэргээс шалтгаалан эмзэг байдалд ордог байна.

Эмзэг байдал нь ийм олон хүчин зүйлээс хамааран бий болдог хэдий ч тус тайланд эдийн засгийн нөхцөл байдлын улмаас ядуурах эмзэг байдалд байгаа өрх, иргэдийн талаар тодруулахыг зорилоо.

Монголд хийгдсэн судалгаануудаас харахад олон хүүхэдтэй ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд, 100-гаас доош малтай өрх, ажилгүйчүүд, суурь боловсролгүй хүмүүс, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гудамжны болон өнчин хүүхдүүд ядууралд өртөх нь элбэг байна. Эмзэг байдал, эмзэг бүлэг гэсэн ойлголтуудыг яг адилтгаж хараахан болохгүй гэдгийг дээр тэмдэглэсэн. Эмзэг байдал нь илүү өргөн хүрээтэй бөгөөд өнөөдөр амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээгүүр орлоготой, ядуу биш байлаа ч гэсэн эдийн засаг, байгаль, нийгмийн гэнэтийн өөрчлөлтийн улмаас ядуурч болзошгүй өрх, иргэд хамрагдаж байна. Харин эмзэг бүлэгт хамаарагдаж байгаа өрх, иргэд нь ядууралд өртсөн, ядуурлаас гарахад нь тэдэнд туслалцаа үзүүлэх шаардлагатай гэдгээрээ онцлог юм.

ННФ, МУИС-ийн ЭЗС-тай хамтран 2009 оны 11-р сард хийсэн Хэрэглэгчийн итгэлийн индекс тооцох хоёр дахь түүвэр судалгааны үр дүнгээс харахад одоогоос хагас жилийн өмнө дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө илүү хүчтэй байх үед Улаанбаатар хотод ядуурлын түвшин 57.5 хувьтай байсан бол өнөөгийн байдал

тааруухан байгаа ч хагас жилийн өмнөхөөс нилээд дээрдсэн гэж үзэж байгаа өнөө үед 43.2 хувь байна. Энэ тооцоог хийхдээ амьжиргааны баталгаажих доод түвшинг өөрчлөхгүйгээр<sup>12</sup> авч үзсэн бөгөөд энэ хагас жилийн хугацаанд үнийн түвшин өөрчлөгдөөгүй гэж Монголбанк тодорхойлсон. Харин 2009 онд шинэчлэн тогтоосон амьжиргааны доод түвшин 101,100 төгрөгөөр тооцвол Улаанбаатар хотод ядуурлын түвшин 62.2 хувь болж өсч байна. Өөрөөр хэлбэл, шинэчилсэн түвшнээр ядуурлыг тооцохоос өмнө ядуу бус байсан өрхүүд ядууралд орж байгаа нь эдгээр өрх эмзэг байдалд байсныг харуулж байна.

Эдийн засгийн хямралын үр дагавар өрх, иргэдэд хэрхэн нөлөөлж байгаа талаар Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас зохион байгуулж хийсэн Социологийн тандах судалгааны үр дүнгээс үзвэл өрхийн сарын дундаж орлого нь 81,000-300,000 төгрөг хүртэл орлоготой иргэдийн хувьд эдийн засгийн хямрал маш хүчтэй нөлөөлсөн гэсэн хариултад бүсийн ялгаа ажиглагдахгүй байна. Түүнчлэн өрхийн сарын дундаж орлого 300,000 төгрөгөөс дээш буюу орлогын түвшин нэмэгдэх тусам хямрал маш хүчтэй нөлөөлж байна гэж үзсэн хувь багасч байгааг харж болох юм.<sup>13</sup> Энэ нь хаана амьдарч байгаа бүсийн ялгаанаас үл хамааран эдийн засгийн хямралд орлого багатай иргэд нэн түрүүнд өртдөг буюу эмзэг байдалд байдгийг баталж байна.

Ядуурал нь өрх, иргэдийн эмзэг байдалд хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл юм. Учир нь ядуурал гэдэг бол иргэд наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй хомсдол, дутагдалд

12 Амьжиргааны доод түвшин 94800 төгрөг

13 НХХЯ, Социологийн судалгаа. 2009 он



орж байгаатай холбоотой. Ядуу байхын хирээр байгаль, нийгмийн баялгаас хүртэх боломжоо алдах, улс төрийн эрх мэдлээ бүрэн дүүрэн эдлэхгүй байх улмаар байгалийн гамшиг, эдийн засаг, нийгмийн шокуудыг даван туулах чадвар сул, шокуудад хамгийн түрүүнд нэрвэгддэг байна. Одоогоор ядуу биш ч гэсэн олон өрхүүд гэнэтийн өөрчлөлт, тэр дундаа ажилгүй болох, төлөвлөгдөөгүй зардал өсөх, өвчинд нэрвэгдэх болон эдийн засаг буурах зэрэгт эмзэг байдаг. Ядуурал бол нийгмийн эмзэг байдалд хүчтэй нөлөөлдөг ч энэ хоёр нь яг адил зүйл биш юм. Жишээ нь, мянгат малчин зуд турхан, ган гачиг тохиолдсоноор өөрийн үндсэн хөрөнгө болсон малаа алдаж үгүйрэн хоосрох магадлал бий. Гэтэл тэрхүү мянгат малчин өнөөдөр ядуу хүн биш.

“Хэрэглэгчийн итгэлийн индекс” тооцсон түүвэр судалгаанаас үзэхэд сүүлийн хагас жилд Улаанбаатар хотын өрхийн аль ч бүлгийн хувьд ядуурлын түвшин буурсан байна. Ялангуяа, дээдээс доогуур боловсролтой өрхүүдийн дунд болон гэр хороололд ядуурлын түвшин бараг 20

пунктээр буурчээ. Энэ нь эдийн засгийн уналтын үед юуны түрүүнд эмзэг байдалд байгаа өрхийн амьжиргаа мууддаг болохыг харуулж байна.

Судалгаанаас үзвэл, гэр хорооллын ядуурлын түвшин 55.6 хувь байгаа нь орон сууцанд амьдардаг өрхүүдээс 2.5 дахин өндөр, дээд боловсролтой өрхүүдийн 20 хувь нь ядуу байхад, дунд болон бага боловсролтой өрхийн талаас илүү нь ядуу байна. Үүнээс үзвэл ядууралд нөлөөлж байгаа нэг гол хүчин зүйл бол боловсролын түвшин гэдэг нь тодорхой байна.

Дэлхийн нийтийг хамарсан хямралын нөлөөгөөр манайх шиг хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт огцом буурч байгаагаас ядуучуудын тоо эрс нэмэгдэв. Хөгжиж буй эдийн засагт ядуурлын түвшин огцом нэмэгдэх нь зайлшгүй шаардлагатай нийгмийн үйлчилгээ болох эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлийн зардлыг эрс өсгөдгөөс төсөвт дарамт учруулдаг. Энэ утгаараа ядуурал өсөхийн хирээр эдийн засагт төрийн оролцоо нэмэгддэг гэсэн таамаглал өндөр байдаг. Өрх, иргэдийн ядуурах, эмзэг байдлыг даван туулахад нийгмийн хамгааллын

## Хүснэгт 2.1. Улаанбаатар хотын ядуурлын түвшин, 2009

		Ядуурлын түвшин (2009 оны 4 дүгээр сар)	Ядуурлын түвшин(2009 оны 11 дүгээр сар )
УБ хотын ядуу өрхийн хувийн жин		57.5 %	43.2%
Ядуу өрхийн тоо		135,081	101487
Өрхийн тэргүүний хүйс	Эм	61.8 %	55.8%
	Эр	56.4 %	41%
Өрхийн тэргүүний боловсролын түвшин	Дээд	34.1 %	19.9%
	Доогуур	75.0 %	56.9%
Байрны нөхцөл	Орон сууц, хувийн байшин	29.8 %	20.9%
	Гэр хороолол	74.7 %	55.8%

Эх сурвалж: “Хэрэглэгчийн илтгэлийн индекс” тооцох түүвэр судалгаа, 2009 оны 4, 11 дүгээр сар





ач холбогдол өндөр юм. Ялангуяа эдийн засгийн уналтын үед нийгмийн хамгаалалд хамрагдагсдын тоо өсч, нийгмийн хамгааллын зардал нэмэгддэг зүй тогтол улс орнуудад нийтлэг байдаг. Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас гаргасан мэдээгээр ажилгүйдлийн тэтгэмж авч буй хүний тоо тасралтгүй нэмэгдэж иржээ. Тухайлбал, 2009 оны эхний улиралд 3,201 , хоёрдугаар улиралд 6,010 , гуравдугаар улиралд 8,494 хүн болжээ.

2008 оны сүүлийн улирлаас манай улсын санхүү эдийн засгийн байдал хүндэрч эхэлсэн ба 2009 оны эхний улиралд огцом уналттай тулгарсан. 2009 оны хоёрдугаар улиралд эдийн засгийн үзүүлэлт бага зэрэг сайжирсан ч уг үзүүлэлт нь тогтвортой бус, улирлын хэлбэлзэлтэй болох нь гуравдугаар улирлын үзүүлэлтээс харагдаж байна. Ийнхүү хямралын сөрөг нөлөө бага зэрэг буурч байгаа боловч бүрмөсөн арилж чадаагүй өнөө үед нийгмийн хамгааллын зардлыг огцом танахгүй байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ядуурал нь олон талт үйл явц, энэ нь зөвхөн орлогын гачигдал, дутагдалтай холбоотой ойлголт биш билээ. Ядуурал өсөхийн хирээр нөөц баялгаа хэрхэн ашиглаж, хэрэглэх ур чадвар тэр дундаа эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, улс төрийн төлөөлөлд оролцох оролцоонд бэрхшээл, гажиг үүсдэг. Ядуурлын түвшин өндөртэй улс орнуудад улс төрийн тогтворгүй байдал, авилгал, хээл хахууль, хүний эрх зөрчигдөх явдал өндөр байдаг байна. Бид өмнөх тайландаа<sup>14</sup> ОУВС-ийн таамаглалаар хөгжиж буй улс орнуудын ДНБ-ий бодит өсөлт 2009 онд өмнөх оноос 4 орчим пунктээр буурахаар байгааг дурдсан.

<sup>14</sup> Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө, гуравдугаар улирлын тайлан, 2009 он

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нэг пунктээр буурах нь ядуучуудын тоог 20 саяар нэмэгдүүлдэг болохыг Дэлхийн Банкны судалгаа харуулсан байдаг. Тэгвэл энэ онд хөгжиж буй манайх шиг орнуудад ядуучуудын тоо 80 саяар өсч болзошгүй юм. Эдийн засгийн өсөлт буурахад ядуурлын хэмжээ огцом нэмэгдэж, ядуурлыг бууруулах чиглэлээр хэдэн арван жилд авч хэрэгжүүлсэн хүчин чармайлт үр дүнгүй болоход хүрдэг байна.

Эдийн засгийн өсөлт болон ажилгүйдлийн хамаарлыг 1962 онд Америкийн эдийн засагч Окун эмпирик судалгаагаар баталж гаргасан билээ. Окун хуулиар бүтээгдэхүүний хэмжээ гурван хувиар өсөхөд ажилгүйдлийн түвшин дөнгөж нэг хувиар буурдаг. Тэгвэл эдийн засгийн өсөлт болон ядуурлын хооронд хүчтэй хамаарал байдаг ч ядуурлын тодорхой түвшинг бууруулахад шаардлагатай эдийн засгийн өсөлтийн оновчтой хэмжээг тооцож гаргахад төвөгтэй байдаг нь ядуурал олон талт нийгмийн үзэгдэл болохыг илтгэж байна. Эдийн засгийн өсөлт бол ядуурлыг бууруулах зайлшгүй нөхцөл болдог. Дан ганц эдийн засгийн өсөлтөөр ядуурлыг бууруулах боломжгүй, өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулах зайлшгүй нөхцөл мөн хэдий ч хүрэлцээтэй нөхцөл болж чаддаггүй. Тиймээс ядуурлыг бууруулахад эдийн засгийн өсөлт дээр суурилсан, хоорондоо уялдаа холбоо бүхий бодлогын стратеги боловсруулж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллах нь нэн чухал.

Ядуурал бол дан ганц эдийн засгийн өсөлтийн бус эдийн засгийн хөгжлийн асуудал хэмээн тодорхойлогдох нь олонтаа байдаг. Эдийн засгийн өсөлт бүр эдийн засгийн хөгжлийг бий болгодоггүй, харин эдийн засгийн хөгжил болгонд эдийн засгийн өсөлт заавал байдаг.



М.Тодара<sup>15</sup> нарын хөгжлийн эдийн засагчид тэмдэглэхдээ аливаа хөгжиж буй орны эдийн засаг 10 хувиар өссөн ч ядуурал, ажилгүйдлийн түвшин буураагүй, орлогын хуваарилалт сайжраагүй бол тухайн эдийн засагт хөгжил байна гэж үзэх боломжгүй гэжээ.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2004-2008 оны хооронд жилд дунджаар 9 хувиар өссөн бөгөөд энэхүү эдийн засгийн өсөлт нь нэг хүнд ногдох ДНБ-ийг 721 ам. доллараас 1,960 ам. долларт хүргэсэн болохыг бид өмнөх тайландаа дурдаж байсан. Сүүлийн таван жилийн туршид дунджаар 9 хувийн өсөлттэй гэдэг бол өндөр өсөлт. ҮСХ-ноос гаргасан түүвэр судалгаагаар 2002-2003 онд хүн амын 36.1 хувь нь ядуу байсан бол 2006 онд 32.2 хувь болж буураад 2007-2008 онд эргээд нэмэгдэж 35.2 хувь болсон байна. Хялбаршуулсан дүгнэлт боловч, тоон үзүүлэлтээс нийт дүнгээр таван жилийн туршид эдийн засгийн 9 хувийн өсөлтийн үр дүнд ядуурлын түвшин 0.9 хувиар буурчээ. Эндээс манай улсад эдийн засгийн өсөлт болон ядуурлын хамаарал сул, эдийн засаг нэг хувиар өсөхөд ядуурлын хэмжээ дөнгөж 0.1 орчим хувиар буурсан нь харагдлаа.

Эдийн засгийн өсөлтийн үр дүнд ядуурал буурахгүй байгаа нь орлого хуваарилалттай холбоотой бөгөөд тэгш бус хуваарилалтын нөлөө хүчтэй байгаа үед ядуурлыг төдийлөн багасгаж чадахгүй байна. Цаашилбал, ядуурлын түвшин дорвитой буураагүй нь эдийн засгийн өсөлтийн ядууралд үзүүлэх нөлөө нь тэр даруй ажиглагдах боломжгүй эсвэл 30 гаруй хувийн ядуурлын түвшингээс доош буулгах нь илүү их хүчин чармайлт шаардсан зүйл байхыг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ нийт өрхийн гуравны нэгээс

илүү хэсэг нь ядуу бөгөөд ядуурлын түвшин буурахгүй байгаа нь өөрөө нийгмийн эмзэг байдал өндөр байгааг илтгэж байна. Эмзэг байдал болон ядуурлын хамаарлын талаар ялгаатай үзэл, хандлага байдаг ч олонхи судлаачид эмзэг байдлын түвшин гэдэг бол өнөөдөр ядуу эсэхээс үл хамааран ирээдүйд өрх гэр эсвэл хувь хүний хэрэглээ буурч ядуурах магадлал гэдгийг дээр тэмдэглэсэн байгаа. Эмзэг байдал болон ядуурлын харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад, эмзэг байдлаас ядууралд өртөх үйл явцыг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг чухалчилдаг. Үүнд: нэгдүгээрт, эмзэг байдлын шугам<sup>16</sup>-ыг нарийвчлан үнэлэх, хоёрдугаарт, өрх гэр эсвэл хувь хүмүүсийн байнгын тогтмол орлогыг үнэн зөв тооцох, гуравдугаарт, ядуурлын шугамыг нарийвчлан үнэлж сонгох шаардлагатай.

Бид өмнөх тайландаа<sup>17</sup> ядуурлын түвшинг тодорхойлоход үндэс болгодог амьжиргааны баталгаажих доод түвшин 2004 онд бүс нутгуудад 20,200-26,500 төгрөг байснаа 2008 онд 65,600-73,300 төгрөг болж ойролцоогоор гурав дахин өссөн ч тус түвшинг тогтоохдоо үндэс болгон хэрэглэдэг Монгол хүний хүнсний хоногийн (нэг хүнд хоногт ногдохоор) 2,100 илчлэгийн хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй болохыг тэмдэглэсэн. 1996 оноос одоог хүртэл Монгол хүний хүнсний хоногийн илчлэгийн хэмжээнд ямар нэгэн өөрчлөлтгүй хэвээр

15 Michael P. Todaro, Stephen C. Smith "Development Economics", 10th edition, 2008

16 Өрхүүдийн эмзэг байдлаас ядууралд орох түвшинг үнэлэх үнэлгээг сайжруулахын тулд ядуурлын шугамыг өндрөөр авах (жишээ нь өдөрт 1 ам.доллараас бус 2 ам. доллараас бага орлоготойг сонгох), өрхүүдийн байнгын орлогыг үнэлснээр өнгөрсөн дундаж орлогыг сонгож авах ингэснээр эмзэг байдлын шугамыг түүний 50 хувиар тогтоох (UNU-WIDER Special Issue of Oxford Development Studies, 37(3): September 2009).

17 Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг бүлэг, эхний хагас жилийн тайлан, 2009 он



байна. Амьжиргааны баталгаажих доод түвшинг тогтооход 2,100 кк илчлэг хэрэгтэй байдаг бол амьжиргааны зохистой түвшинг хангахад хэдий хэмжээний илчлэг шаардлагатай байдаг, дундаж орлоготой хувь хүн хэдий хэмжээний илчлэгтэй хүнсийг нэг хоногт хэрэглэдэг зэрэг асуултууд байсаар байна.

2004 оноос 2008 онд нэг хүнд ногдох ДНБ өсч 1,960 ам. долларт хүрсэн нь манай улсыг Дэлхийн Банкны бага орлоготой орнуудын жагсаалтаас гаргаж дундаж орлоготой орнуудын тоонд оруулсан гэдгээс дундаж орлого өөрчлөгдсөн байх талтай. Зарим улс орон дундаж орлогын 50 хувиар эмзэг байдлын шугамыг тогтоох явдал байдаг. Тэгвэл дундаж орлогын түвшин өөрчлөгдөх нь эмзэг байдлын шугамыг өөрчилнө. Эмзэг байдлын шугам өөрчлөгдөхөд эмзэг байдлын хэмжээ бас өөрчлөгдөнө. Ядуурал болон эмзэг байдлын шугамыг зөв тогтоох нь нарийвчилсан үнэлгээ шаарддаг бөгөөд түүнийг хэрхэн тодорхойлсноос түвшин нь өөрчлөгддөг маш мэдрэмтгий үйл явц билээ. ХИИ-ийг үнэлэх 2 дахь түүвэр судалгаа<sup>18</sup> -ны тайланд Улаанбаатар хотын өрхийн амьжиргааны баталгаажих доод түвшин, ядуурлын шугам бага зэрэг өөрчлөгдөхөд ядуу өрхийн тоонд эрс өөрчлөлт орж байгааг тэмдэглэсэн. Ядуурлын шугамыг нарийвчлан тодорхойлж нямбай ажиллах нь ядуурлын түвшин төдийгүй эмзэг байдлын түвшинг үнэлж, тооцоход цаашилбал ядуурлыг бууруулах стратегийг боловсруулахад ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд манай улсад хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнээс эдийн засгийн өсөлт болон ядуурлын хоорондын харилцан хамаарал

нэлээд сул, зарим талаар огт хамааралгүй мэт ойлгогдож яригдаж байгаа нь харамсалтай. Түүнчлэн эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах үйл явцын уялдааг ханган ажиллаагүй байдал харагдаж байна. Тэгэхээр ядуурлыг бууруулах бодлого нь түүний хамгийн чухал үндэс суурь болсон эдийн засгийн өсөлтийн бодлогоос ангид явагдаж ирсэн нь ядуурлын түвшин дорвитой буурахгүй байхад нөлөөлжээ. Ядуурлыг бууруулах бодлогын баримт бичгүүдэд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахыг онцолсон байдаг ч уг бодлогын хэрэгслээ мөрдлөг болгон ажилладаггүй, бодлого хэрэгжилтийн уялдаа сул, зөрүүтэй байдаг явдал үргэжилсээр байна.

Монгол Улсын хүн амын давхаргын бүтцийг авч үзвэл 60 хувь нь доод давхаргад хамаарч ядуу, эмзэг байдалтай амьдардаг бол хүн амын ердөө 5 хувь нь дээд, харин 10 хувь нь дунд, 25 хувь нь дундаас доошхи давхаргад хамаарагддаг гэсэн ойролцоо тооцоо байдгийг өмнөх тайландаа дурдаж байсан.<sup>19</sup> Хүн амын дийлэнх хэсэг нь тарчиг, ядуу амьдралтай манай улсад ядуу хүмүүст хүнд байна, тэдэнд тусалж, тэднийг дэмжицгээе хэмээн уриалж мөнгө амлаж, олгож байгаа нь олон хүнд зөв зүйтэй сонсогддог, буруутгах аргагүй зүйл хэдий ч чухам энэ нь үнэхээр ядуурлыг бууруулахын төлөө хийж буй бодит алхам болж чадсан эсэх нь эргэлзээтэй юм. Ядуурлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь макро түвшнээс микро түвшин рүү чиглэсэн байгаа бөгөөд тэдгээрийн микро түвшинд, ядуу иргэдэд үзүүлсэн үр дүн хангалтгүй хэвээр байна. Тиймээс ядуурлыг бууруулах ямар

18 "Хэрэглэгчийн итгэлийн индекс" түүвэр судалгаа, 2 дахь судалгааны тайлан, 2009 он

19 Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг бүлэг, эхний хагас жилийн тайлан, 2009 он



бодлого хэрэгтэйг бодлого боловсруулагчид зөвхөн хэлэлцэн зөвшилцөх бус ядуу иргэд ядуурлаас гарахын тулд чухам юу чухал гэж үзэж байгаа, түүний шалтгаан, учир холбогдлыг судалж тодорхойлон түүнд бодлогоо чиглүүлэх нь хөтөлбөрийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн чадвартай ядуу иргэн сар болгон 10,000 төгрөг авах эсвэл байнгын тогтвортой ажилтай болохын алийг илүүд үзэхийг, нэг жил хүлээгээд байнгын ажилтай болоход хэдэн хувь нь бэлэн байгаа эсэхийг, хот, аймаг, сумын төвийн болон хөдөөгийн ядуу өрхийн хувьд ядуурлаас гарах арга замаа хэрхэн ялгаатай эрэлхийлж байгаа зэргийг судалмаар байна. Микро түвшнээс макро түвшин рүү чиглэсэн бодлого нь макрогоос микро руу чиглэсэн бодлогыг бодвол боловсруулах шатандаа ур чадвар, хугацаа шаардсан, зардал өндөртэй байдаг ч бодлогын үр дүн сайн байдаг байна.

Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэсэнээр өрхийн тэргүүлэгч нь ажилгүй<sup>20</sup>, ажил эрхэлдэггүй<sup>21</sup> өрхүүд ядууралд өртөх магадлал хамгийн өндөр байдаг байна. Өнгөрсөн сард Улаанбаатар хотод хийсэн ХИИ-ийн түүвэр судалгааны үр дүнгээс доогуур боловсролтой эсвэл гэр хороололд оршин суудаг иргэд, эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бөгөөд ажилгүйдлийн түвшин өндөр байх тусам амьжиргааны түвшин

муу байдгаас тэдний дунд ядуурлын түвшин өндөр байна. Дээрх бүлгийн иргэдийн ядуурах эмзэг байдал өндөр байгаагийн сацуу эдийн засгийн уналтын үед тэдний амьжиргаа, ажил эрхлэлт нэн тэргүүнд эрсдэлд өртдөг болох нь ажиглагджээ.<sup>22</sup>

Нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад эдийн засгийн өсөлтийн үр шимийг ядуу иргэдэд дахин хуваарилах, ингэхдээ зөвхөн мөнгөн хэлбэрээр олгох, мөнгөн хэлбэрээр олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн төрөл зүйл, хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулсан нь нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад төдийлөн үр шимээ өгсөнгүй. Нийгмийн хамгааллын чиглэлээр олгож ирсэн мөнгөн тэтгэлэг, тэтгэмж, хөнгөлөлт нь олон хүнд чухал, зөв зүйтэй сонсогдож, дуулдаж байж болох ч бусад хөтөлбөрүүдтэй уялдаа холбоо тааруу, хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн зэрэг нь тодорхой бус байсан. Хүлээгдэж буй үр дүн, хэдий хугацаанд үргэлжлэхээр төлөвлөгдөж буй зэрэг нь тодорхой бус, сайн боловсрогдоогүй хөтөлбөрүүд нь нийгмийн савалгаа, хэлбэлзлийг улам нэмэгдүүлж, хэрэгжүүлээгүй байснаасаа ч илүү муу үр дагавар авч ирж болзошгүй байдаг. Эдийн засаг өндөр өсөлттэй байхад мөнгөн тэтгэлэг олгосон хөтөлбөрүүд хэт тэлж байснаа эдийн засаг унаж эхлэхэд тэдгээрийг огцом танах болсон. Нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа богино хугацаанд хэрэгжих нь үр дүн тааруу, харин дунд болон урт хугацаанд тогтвортой үргэлжлэх нь илүү үр дүнтэй байдаг.

Тиймээс энэ чиглэлийн хөтөлбөрийг дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэхийн тулд

20 Ажилгүй хүн гэдэг нь хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй хүнийг хэлнэ.

21 Ажил эрхэлдэггүй хүн гэдэг нь хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай хэдий ч ажил идэвхитэй хайж байгаа бус, хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүнийг хэлнэ.

22 “Хэрэглэгчийн итгэлийн индекс” түүвэр судалгаа, 2 дахь судалгааны тайлан, 2009 он



тус хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ, хүлээгдэж буй үр дүн, шаардагдах төсөв санхүү хүрэлцээтэй эсэх, удирдлагын хувьд боломжтой эсэхийг тооцсоноор хэрэгжүүлэх шаардлагатай үгүйг шийдвэрлэх нь зүйтэй. Тус тайлангийн дараагийн хэсэгт нийгмийн хамгааллын тусламж дэмжлэгийн нэг хэлбэр болох бэлэн мөнгөний тусламжийг жишээ болгон авч, энэ талаарх үзэл баримтлал, дэлхийн бусад улсуудын туршлага, сургамжийг орууллаа.

## 2.2. Нийгмийн эмзэг байдал, ядуурал ба бэлэн мөнгөний тусламж

Эдийн засгийн өндөр өсөлттэй байсан сүүлийн жилүүдэд улсын төсөвт нийгмийн хамгаалалын чиглэлээр олгогдсон тэтгэмж, тэтгэвэр, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ болон төрөл зүйл огцом нэмэгдсэнээр 2008 онд 2003 онтой харьцуулахад нийгмийн халамжийн үйлчилгээний зарлага даруй 11 дахин өссөн бол уг үйлчилгээг хүртсэн иргэдийн тоо 17 дахин өссөнийг бид өмнөх тайландаа онцолсон. Манай улсад ашигт малтмалын орд газрын гэрээ зурагдсантай холбоотой мөнгөн тэтгэмж, тусламж олгох асуудал Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд нэлээд яригдаж байгаа билээ. Иймээс нийгмийн тусламж дэмжлэгийн нэг хэлбэр болсон бэлэн мөнгөний тусламж (*cash transfer*)-ийн талаар тайлангийн энэ хэсэгт тусгайлан авч үзэхээр зорив.

Бэлэн мөнгөний тусламж нь нийгмийн тусламж дэмжлэгийн нэг хэлбэр бөгөөд улс төр, санхүү, үйл ажиллагааны өөрчлөлтийн чиглэлээр засгийн газар, донор болон төрийн бус байгууллагуудын хүрээнд 2000 оноос эхлэн нэлээд хурдацтай газар авч яригдах болсон билээ. Бэлэн мөнгөний

тусламж нь хөгжлийн болон хүмүүнлэгийн зорилгоор олгогддог нийгмийн тусламж дэмжлэгийн нэг хэлбэр бөгөөд бүтээгдэхүүн болон үйлчилгээг тогтворжуулах, өсгөх үүднээс зах зээлийн тогтолцоогоор дамжуулан хүнс болон бусад материаллаг зүйлсээр хангах, нийгмийн үйлчилгээгээр дамжуулан эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээнээс хүртэх боломжийг бүрдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм.

Бэлэн мөнгөний тусламж гэдэг нь шууд бэлэн мөнгө өгдөг хэлбэрээс илүү өргөн хүрээтэй ойлголт. Бэлэн мөнгөний тусламж гэдэгт хувь хүн болон өрхүүдэд засгийн газар, бусад байгууллагаас бэлэн мөнгө олгохоос гадна нийтийг хамарсан ажилд хамруулан бэлэн мөнгө өгөх, тасалбарын (*voucher*) хөтөлбөр хэрэгжүүлэх, зарим бүлгийн иргэдийг тодорхой төлбөрөөс чөлөөлөх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орцыг худалдан авах, хүнсний болон хүнсний бус зүйл худалдан авахад зориулж нөхцөлт хэлбэрээр бэлэн мөнгөөр (төлбөрийн карт олгох) туслахын аль алиныг хамруулдаг.<sup>23</sup>

Бэлэн мөнгөний тусламжийн үндсэн зорилго нь зөвхөн хэрэглээнд нөлөөлөх явдал хэдий ч хэрэглээг дэмжсэнээр үйлдвэрлэлд зарим нөлөө үзүүлдэг жишээ нь хүнсний эрэлт өссөнөөр үйлдвэрлэл өсөх, түүнчлэн эрүүл мэнд болон боловсролын хөрөнгө оруулалтын нөлөөг нэмэгдүүлэх, нийтийг хамарсан ажилд хамруулан бэлэн мөнгө олгосноор капиталыг нэмэгдүүлэх, цаашилбал, нийгмийн хамгааллын эрсдэлийг бууруулахад тус дэм болдог гэж үздэг. Гэхдээ бэлэн мөнгөний тусламж нь нэгд, иргэдийн дунд ажил эрхлэх сонирхлыг бууруулдаг, хоёрт,

23 DFID (2005) "Social Transfers and Chronic Poverty: Emerging Evidence and the Challenge Ahead".



бэлэн мөнгөний тусламж нь зөвхөн хэрэглээнд тус дэм болдгоос биш улс орны үйлдвэрлэл, бүтээмжид ямар нэгэн нөлөө үзүүлдэггүй гэсэн эсрэг хандлага нэлээд хүчтэй байдаг.

Сүүлийн жилүүдэд манай улсад хэрэгжүүлсэн бүх нийтийг хамарсан мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн асуудлыг зорилтот бүлэгт чиглүүлэх нь чухал болохыг бид өмнөх тайландаа тэмдэглэж байсан. Барриетос, Дэ Жонг<sup>24</sup> нарын Өмнөд Африк, Латин Америк болон шилжилтийн эдийн засагтай зарим оронд хийсэн судалгаанаас өрхийн ядуурлыг бууруулах зорилгоор хүүхдэд олгосон бэлэн мөнгөний тусламж нь ядуурлын түвшинг бууруулахад эерэг нөлөөтэй байжээ гэж үзсэн. Ядуу гэр бүлд төрсөн хүүхдүүд хоол тэжээл болон бусад төрлийн хомсдолд байснаас эрүүл мэнд муудах, сургуульд хамрагдаж чадахгүй зэргээс үүдэн урт хугацааны туршид ядууралд нэрвэгдэхэд орлогын гачаал хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг байна. Эндээс манай улсад олгож байсан хүүхдийн мөнгө нь үргэлжлэн олгогдсоноор урт хугацаандаа орлого багатай, ядуу гэр бүлийн хүүхдэд тус дэм үзүүлнэ гэж таамаглаж болно.

Тэгвэл Каквани, Соарэс<sup>25</sup> нарын Африкийн 15 оронд хийсэн судалгаагаар өрхийн орлого нэмэгдэх нь сургуульд хамрагдалтын түвшин нэмэгдэхэд нөлөө үзүүлэхгүй байгааг харуулжээ. Тэдний судалгааны үр дүнгээс бэлэн мөнгөний тусламжийг зорилтот бүлэгт, нөхцөлт хэлбэрээр олгох нь бага зардлаар сайн үр дүнд хүрэхэд ач тустай байна. Гэхдээ зорилтот бүлэгт хүрч үйлчлэх удирдлагын зардлыг нарийвчлан тооцох

нь чухал. Манайх шиг хөгжиж буй эдийн засагт энэ чиглэлийн үйл ажиллагааны удирдлагын зардал нэлээд өндөр байдаг. Удирдлага, үйл ажиллагааны зардал өндөр байх тусам зорилтот бүлэг рүү чиглэсэн бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрийн үр ашигтай байдал мууддаг. Тэгэхээр нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг рүү чиглүүлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ давын өмнө зардал үр ашгийн шинжилгээ хийх нь чухал. Бид өмнөх тайландаа нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэг рүү чиглүүлэх нь эерэг болон сөрөг үр дагаврыг бий болгодог болохыг тэмдэглэсэн байгаа.

Зорилтот бүлэг рүү чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхийн тул амьдарч буй газар, байршлыг харгалзан хөтөлбөр хэрэгжүүлэх нь бий. Жишээ нь, хотын захын гэр хорооллын гэрт амьдардаг өрхийн 0-16 насны хүүхдэд эсвэл өрх гэр бүлд олгох мөнгөн тусламж гэх мэт ангилан үзэж, туршин хэрэгжүүлж, харьцуулан судалснаар зорилтот бүлгээ хэрхэн сонгохоо тодорхойлох боломжтой.

Бодлогын хүрээнд бэлэн мөнгөний тусламжийг нэгдүгээрт, улс төрийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх болон тус хөтөлбөрийг даах чадвартай эсэх, хоёрдугаарт, бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх, эрэлтийг хангах төрийн болон хувийн бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн хэмжээ хангалттай байгаа эсэх, гуравдугаарт, зорилтот бүлэгт чиглэсэн эсвэл нөхцөлт хэлбэрийн бэлэн мөнгөний тусламж эсвэл зорилтот бүлэгт нөхцөлт хэлбэрээр олгох бэлэн мөнгөний тусламж хөтөлбөр гэж ангилж авч үзэж байна.

24 Barrientos, A & DeJong, J. (2004) "Child Poverty and Cash Transfers". Childhood Poverty and Research Policy Centre Report

25 Kakwani, N. Soares, F. and Son, H. "Cash Transfers for School-Age Children in African Countries: Simulation of Impacts on Poverty and School Attendance" Development Policy Review, 2005




Нэгдүгээрт, концепцийн хувьд хөтөлбөрийг даах чадварын шалгуур үзүүлэлт нь харьцангуй ойлголт юм. Бодлого боловсруулагчид нь нийгмийн халамжийн функцийг оновчтой түвшинд хүргэхэд нийгмийн нөөцийг хуваарилахыг эрмэлздэг. Энэ нь практикт, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй нийгмийн хөтөлбөрийг даах чадвараар хэмжигддэг. Жишээ нь, бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрийг даах чадвар нь тус хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төрлийн зардлыг нарийн тооцохоос эхэлнэ. Бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад хөрөнгө оруулалт тухайлбал, зах зээл, зам харилцаа, үйлчилгээний хүртээмжийн асуудал хөндөгдөнө. Эдгээрт хөрөнгө оруулалт хийлгүйгээр зөвхөн бэлэн мөнгөний тусламж нь хэрэглээнд эерэгээр нөлөөлж, өргөн утгаараа хөрөнгийг бий болгох, хамгаалах зорилгоо биелүүлж чадахгүйд хүрдэг. Цаашилбал, бэлэн мөнгөний тусламж нь нягтлан бодох бүртгэлийн өөр ялгаатай механизмыг шаарддаг ба удирдлагын хувьд шинэ ачааллыг бий болгодог. Бэлэн мөнгөний тусламжийн хөтөлбөрөөр хүнсний зүйл худалдан авахад нь зориулж төлбөрийн карт олгож болно. Тэгвэл хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг хянаж байх үр ашигтай мониторингийн систем, үнийн өөрчлөлтийн тооцоог төлбөрийн картад тусгадаг, уян хатан үйл ажиллагааны систем шаардлагатай. Энэ нь удирдлагын нэмэгдэл ачаалал, зардлыг шаарддаг.

Хоёрдугаарт, зах зээлийн нөхцөлд ч гэсэн, бэлэн мөнгөний тусламж хүртэгсэд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнээ худалдан авснаар дараах асуудал бий болдог. Худалдан авах чадварын нэмэгдэл нь дор хаяж богино хугацаанд инфляцийг өсгөдөг. Учир нь,

эрэлтийн өөрчлөлтөд үйлдвэрлэл хариу үйлдэл хурдан үзүүлдэг. Түүнчлэн, тодорхой төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг орон нутгийн зах зээлд нийлүүлэхэд хүндрэл үүсдэг тул үүнд төрийн зүгээс нийлүүлэлтэд анхаарах шаардлагатай тулгарна. Жишээ нь, нялх хүүхдүүдэд хүүхдийн тэжээл, жирэмсэн эмэгтэйчүүдэд сүү, аарц, өндөг өгөхөөр шийдсэн гэвэл эдгээр бүтээгдэхүүнийг бүх цэгт, хангалттай хэмжээтэй байлгахад анхаарах хэрэгтэй болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө хүнсний бүтээгдэхүүний боломж хүрэлцээтэй холбоотой дагалдах бүтцийн болоод институцийн өөрчлөлтийг хийхгүй бол үнийн өсөлт бий болно. Алслагдсан орон нутагт хүнсний бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэрэг нь байдлыг муутгах нөлөөтэй.

Гуравдугаарт, зарчмын хувьд зорилтот бүлэгт, нөхцөлт хэлбэрээр мөнгөн тусламж үзүүлэх нь яг хэрэгтэй хүмүүст хамгийн хэрэгтэй зүйлийг өгч байгаа, ядуурлыг бууруулахад зардлын үр ашигтай байдлыг нэмэгдүүлж буй гэдгээрээ ач холбогдол өндөр байдаг. Бэлэн мөнгөөр зорилтот бүлэгт туслах нь зорилтот бүлэг болон хөтөлбөрийн зорилгыг маш тодорхой болгохыг шаарддаг. Зорилтот бүлгийн шалгуур нь аль болох энгийн бас ойлгомжтой, тодорхой байх нь ашиг хүртэгсдийг дэмжихэд хамгийн чухал юм. Харин хэрэгжилт тааруу байснаас энэ нь нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад хамгийн үр ашиг муутай хэлбэр болох нь бий. Зорилтот бүлгийг тодорхойлохдоо орлогоор тооцох хандлага нийтлэг байдаг, гэтэл зарим бүс нутагт орлогоор тооцох боломжгүй байдаг. Тэгвэл газар зүйн байршил зорилтот бүлгийг сонгох нэг шалгуур байж болно.

Бид өмнөх тайландаа Засгийн газрын толилуулж буй зорилтот бүлгийн нийгмийн халамжийн



үйлчилгээ нь ядуучууд руу, тэтгэмж, тусламж зайлшгүй хэрэгтэй тэр хэсэг рүү чиглэсэн байх болно гэдэг нь дэмжүүштэй гэдгийг тэмдэглэж байсан. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлсэн байхын тулд нэгдүгээрт, зорилтот бүлэгт хандсан хөтөлбөрөө нөхцөлт хэлбэрийн бэлэн мөнгөний тусламжтай аль болох хамтатгах, хоёрдугаарт, тус хөтөлбөртөө тодорхой загвар боловсруулж, боловсруулсан загвар дээрээ сайн ажиллаж, түүний таамаглах чадварыг аль болох нэмэгдүүлэх, гуравдугаарт, хөтөлбөртэй холбоотой бий болох асуудлаар бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийг хэрхэн хангахаа тооцож төлөвлөх, дөрөвдүгээрт, бэлэн мөнгөний тусламж хөтөлбөрөө мөнгөн бус хэлбэрээр туслах бусад үйл ажиллагаатай уялдуулах, тавдугаарт, орчны өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвартай удирдлагын хэлбэрийг хөтөлбөрийн хүрээнд бий болгох, зургаадугаарт, хөтөлбөрийн үйл ажиллагаа ашиг хүртэгсдэд ойлгомжтой, энгийн байхад анхаарах, долоодугаарт, хөтөлбөрийн үйл ажиллагаа ил тод байж, авилгалд өртөхгүй байхад анхаарлаа хандуулах зэргийг онцолж байна.

Засгийн газраас авч байгаа арга хэмжээг багцлан авч үзвэл цаашид төрөөс иргэдэд үзүүлэх нийгмийн шинж чанартай тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг хүний хөгжил сангаас нэгтгэн олгож, нийгмийн халамж, үйлчилгээний шинэчлэл хийх эхлэлийг тавилаа. Төрөөс цаашид нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд бодитой нөлөө бүхий арга хэмжээг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн тогтолцоог дэмжих, олон чиглэлээр олгогдож байгаа нийгмийн хамгааллын дэмжлэгийг нэгтгэх талаар цогц

арга хэмжээ авахаар төлөвлөж байна.<sup>26</sup> Хүний хөгжил сангийн тухай хууль батлагдсанаар хүүхдийн мөнгө, шинэ төрсөн хүүхэд, шинэ гэр бүлийн мөнгийг 2010 оны нэгдүгээр сарын нэгнээс зогсоож нийгмийн шинж чанартай тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг нэгтгэн хүний хөгжил сангаас олгохоор болж байна. Энэ арга хэмжээ нь сайн муу хоёр үр дагавартай гэж бид судлаачийн хувьд үзэж байна. Нэг талаас, хүний хөгжлийг дэмжиж иргэн бүрт хувь хүртээх замаар сонгуулийн амлалтаа хэрэгжүүлж байгаа нь ард иргэдийн хүлээлтийг биелүүлж байгаа эерэг арга хэмжээ. Нөгөө талаас, энэхүү тайланд онцлон тэмдэглэсэн ядуу өрхүүдийг ядуурлаас гарахад нь тодорхой үр дүнгээ өгч дэмжлэг болж байсан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зогсоож, бүх нийтийг хавтгайруулсан шинж чанартай болгож байгаагаараа халамжийн бодлогын тодорхой зорилго чиглэлийг бүрхэгдүүлж байна.

Засгийн Газраас авч хэрэгжүүлэхээр мэдэгдэж буй эмзэг байдал, ядуурлыг бууруулах аливаа арга хэмжээ нь дунд болон урт хугацааны бодлогын стратегитай уялдсан байх зайлшгүй шаардлагатай. Тус тайланд тэмдэглэснээр энэ чиглэлийн бодлогын арга хэмжээ нь дунд болон урт хугацааны туршид тогтвортой хэрэгжиж байж тодорхой үр дүн өгдөг. Тиймээс шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогын арга хэмжээний дунд болон урт хугацаанд тогтвортой хэрэгжих бодит боломж, бололцоог тооцох, шинээр гаргаж буй санал, санаачлага нь зарчмын хувьд нэгэнт хэрэгжиж буй бодлогын стратегийн зарим хэсгийг өөрчлөх шаардлагатай эсэх, эсвэл бодлогын стратегид томоохон өөрчлөлт хийхийг шаардаж буй зэргийг тодорхойлох нь

26 УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд С.Батболдын хэлсэн үгнээс





зүйтэй. Хэрвээ өнөөгийн хэрэгжүүлж буй эмзэг байдал, ядуурлыг бууруулах бодлогын стратегид томоохон өөрчлөлт хийхийг шаардсан бодлогын арга хэмжээг сонгон авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа бол бодлогын баримт бичгийг дахин боловсруулахаас тус үйл ажиллагааг эхлэх хэрэгтэй. Бүхэлдээ богино хугацаанд сонгон авч хэрэгжүүлж, зөв зүйтэй сонсогдож буй олон бодлогын арга хэмжээний үр дүн өгөөж муутай хэвээр байгаа нь нэг талаас бодлогын баримт бичиг сайн боловсрогдож чадахгүй, нөгөө талаас нэгэнт боловсрогдсон баримт бичгийг мөрдлөг болгон ажиллахгүй байгаатай шууд холбоотой.

## ДҮГНЭЛТ

Дэлхийн санхүүгийн хямралын улмаас 2008 оны 11 дүгээр сараас 2009 оны 6 дугаар сарын хооронд Монголын хөдөлмөрийн зах зээл дээр бүртгэлтэй ажилгүйчүүд огцом нэмэгдэж, албан ёсны секторт шинээр ажилд авах нь зогсонги байдалд орж, гадаад улс орон дахь эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан гадаад руу шилжих ажиллах хүчний хөдөлгөөн бууран, ажиллагсад гадаадаас буцаж ирэх, гадаадад ажиллагсдаас ирэх мөнгөн гуйвуулгын хэмжээ багассан зэрэг байдлаар хямарлын нөлөө илэрсэн.

2009 оны хоёрдугаар хагаст манай орны эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 6.6 хувиар өссөн нь нийт ажиллагсдын тоо биш, харин ажилгүйчүүдийн тоо өссөнтэй холбоотой байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт ажиллагсад буурсан бол үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо өссөн байна.

Хямрал эхэлснээс хойш буюу 2009 оны 9 дүгээр сарын албан ёсны ажилгүйдлийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 2.5 хувиар нэмэгдсэн байна. 2009 оны 11 дүгээр сард байсан бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог 2008 оны мөн үеийнхтэй харьцуулахад бүртгүүлсэн ажилгүй хүний тоо улсын хэмжээнд 33 хувиар нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт буурч, ажилгүйдэл илүү ихээр өсч байна. Боловсролын түвшин ахих тусам ажилгүй байх магадлал өндөр байна. Аймгуудын хувьд 2009 оны 11 дүгээр сарын байдлаар нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харцуулахад 32.8 хувиар нэмэгдсэн байна.

Нийслэл дэх албан бус секторт ажилладаг хүмүүсийн тоо оны сүүлийн хагаст буурсан байх магадлалтай байна.

2009 оны хоёрдугаар хагаст хөлөмөрийн зах зээл дээр зарим эерэг үзэгдлүүд ажиглагдаж эхэллээ. Тухайлбал, 2009 оны эхний хагаст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо огцом өссөнөө хоёрдугаар хагаст удааширлаа. 2009 оны дөрөвдүгээр улиралд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо гуравдугаар улиралтай харьцуулахад буурсан байна. Нийт улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хүний тоо тав болон аравдугаар саруудад хамгийн өндөр байсан. Жишээлбэл, аравдугаар сард шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо болон тэдгээрээс ажилд орсон хүний тоо тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл, шинээр ажилгүй болсон, ажил хайж байгаа хүмүүсийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр бүртгүүлсэн ажилгүй хүмүүсээс ажилд орсон хүний тоо ч нэмэгдэх хандлагатай байна.

Нийслэл хотодажилгүйдлийн түвшин 3.3 пунктээр буурч, нийслэл дэх эмэгтэйчүүдийн ажилгүйдэл эрэгтэйчүүдийнхээс илүү буурсан байгаа зэрэг нь ажиллах хүчний ихээхэн хэсгийг шингээдэг нийслэлийн хөдөлмөрийн зах зээлийн байдал аажмаар сайжирч байгааг харуулж байна.

Эмзэг байдал, ядуурлыг бууруулах нь санхүү эдийн засгийн хүндрэлтэй, хямралд өртсөн энэ үедач холбогдлын зэрэг өндөртэй чухал бодлогын арга хэмжээний нэг мөн. Тус бодлогын хүрээнд богино хугацаанд зайлшгүй шаардлагатай зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үгүйсгээгүй ч богино хугацаанд хэрэгжиж буй бодлогын дунд болон урт хугацаанд үргэлжлэн тогтвортой хэрэгжих байдал, үр дүн тааруу байгаа нь Нийгмийн халамжийн чиглэлээр сүүлийн

жилүүдэд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс харагдаж байна.

Эмзэг байдал, ядуурлыг бууруулах аливаа арга хэмжээний богино хугацаанд үзүүлэх нөлөө сул, харин дунд болон урт хугацаанд тогтвортой хэрэгжиж байж үр дүнгээ өгдөг болохыг онцлон тэмдэглэж байна. Энэ чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд нэгдүгээрт, улс төрийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх, тус хөтөлбөрийг даах чадвартай эсэхийг сайтар хэлэлцэх; хоёрдугаарт, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл болон эрэлтийг хангах төрийн ба хувийн бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн хэмжээ хангалттай байгаа эсэхийг тодорхойлох; гуравдугаарт, хөтөлбөрийн зорилтот бүлэг, хамрах хүрээ, хүлээгдэж буй үр дүн зэргийг нарийн тооцох шаардлагатай гэж үзлээ.

Бидний үзэж байгаагаар ядуурлыг бууруулах бодлогыг эдийн засгийн өсөлттэй нягт уялдуулсан бодлогын стратеги боловсруулж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Ядуурлыг бууруулах бодлого нь ядуу өрхийг ядуурлаас гаргах болон ядуурч болзошгүй, ядуурах эмзэг байдалд байгаа өрхүүдийг ядуурахаас урьдчилан сэргийлэх бодлогоос бүрдэх ёстой. Нэгэнт ядуурсан хойно нь ядуурлаас гаргахад цаг хугацаа, хүч хөдөлмөр, санхүүгийн ихээхэн нөөц шаардагддаг бол ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлого явуулснаар цаг хугацаа хожих, өрх иргэдийг ядууралд орохоос сэргийлэх боломж олгоно. Энэ хоёр бодлого нь зарчмын хувьд өөр төдийгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь харилцан адилгүй юм.

Ядуурлыг бууруулах, ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг аймаг, бүс

орон нутаг, нийгмийн давхрага тус бүрээр ялгаатай байдлаар хэрэгжүүлэх шаардлага байгааг харгалзан үзэх хэрэгтэй байна. Ингэснээр бодлогын үр ашигтай байдал, өгөөж өндөр байх болно.

Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгааг үндэсний хэмжээнд хийх шаардлагатай байгаа бөгөөд ийм судалгааг хийснээр ядуурлыг бууруулах, ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлогыг оновчтой, боловсронгуй болгоход ач холбогдолтой гэж үзлээ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Barrientos, A & DeJong, J. (2004) "Child Poverty and Cash Transfers". Childhood Poverty and Research Policy Centre Report

DFID (2005) Social Transfers and Chronic Poverty: Emerging Evidence and the Challenge Ahead. A DFID Practice Paper.

Farrington, J.; Deshingkar, P.; Johnson, C. and Start, D. (eds) (2006) Rural Livelihood Futures: Concepts and Evidence from India. Oxford University Press.

Farrington, J., Slater, R. and Holmes, R. (2004) Social Protection and Pro-poor Agricultural Growth: What Scope for Synergies? Natural Resource Perspectives 91.

Harvey, P., Slater, R. and Farrington, J. (2005) Cash Transfers: Mere 'Gadaffi Syndrome', or Serious Potential for Rural Rehabilitation and Development? Natural Resource Perspectives 97.

Kakwani, N. Soares, F. and Son, H. "Cash Transfers for School-Age Children in African Countries: Simulation of Impacts on Poverty and School Attendance" Development Policy Review, 2005

Michael P. Todaro, Stephen C. Smith "Development Economics", 10th edition, 2008

Ravallion, Martin. 2008. "Bailing out the World's Poorest." Washington, DC.

Ravallion, M. (2003) Targeted Transfers in Poor Countries: Revisiting the Trade-offs and Policy Options. World Bank Policy Research Working Paper 3048. Washington, DC.

Schubert, B. and Goldberg, J. (2004) The Pilot Social Cash Transfer Scheme: Kalomo District, Zambia. Lusaka: GTZ.

Third Asia Development Forum 2001

Weisner, B., P. Blaikie, T. Cannon and I. Davis (2004), At Risk: Natural hazards, people's vulnerability and disasters (2nd ed.), New York: Routledge.

World Bank (2009). Mongolia Monthly Economic Update, Sept-Nov, 2009.

World Bank (2009). Forthcoming. Global Economic Prospects 2009

World Bank (2003) India: Sustaining Reform, Reducing Poverty. Report No. 25797-IN. Washington, DC: Poverty Reduction and Economic Management Sector Unit, South Asia Region, World Bank.

World Bank. 2009. Mongolia Monthly Economic Update, November, 2009.

World Bank. Global Economic Prospects 2009.

Website sources:

US Bureau of Labor Statistics: <http://www.bls.gov/>

World Bank: <http://www.worldbank.org.mn>

International Labor Organization: <http://www.ilo.org>

"Иргэдийн амьжиргааны түвшин тогтоох аргачлал, халамжийн үйлчилгээний хүртээмжийн талаархи судалгааны дүн. Улаанбаатар хот. 2008 он

Монголбанк: <http://www.mongolbank.mn>

Монгол Улс дахь ядуурлын дүр төрх / илтгэл/.2009. он

Нийслэлийн хөдөлмөр нийгмийн хамгааллын газар, нийслэлийн хөдөлмөрийн биржийн тайлан мэдээ. 2009 он

Нийслэлийн хөдөлмөр нийгмийн хамгааллын газрын үйл ажиллагаана тайлан, сараар, 2009 он

“Нийгмийн халамжийн тухай” Монгол Улсын хууль. 2005 он.

НХХЯ, Социологийн судалгаа. 2009 он

ННФ, МУИС-ийн ЭЗС. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө, гуравдугаар улирлын тайлан, 2009 он

ННФ, МУИС-ийн ЭЗС. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг бүлэг, эхний хагас жилийн тайлан, 2009 он

ННФ, МУИС-ийн ЭЗС. “Хэрэглэгчийн илтгэлийн индекс” тооцох түүвэр судалгаа, 2009 оны 4, 11 дүгээр сар.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үндсэн үр дүн

ҮСХ. 2009. Статистикийн сарын мэдээлэл.

## ХАВСРАЛТ. 1

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, байршлаар

Аймаг	2008 оны 11 сар	2009 оны 11 сар	Аймаг	2008 оны 11 сар	2009 оны 11 сар
Архангай	1753	1882	Сүхбаатар	1000	1332
Баян-Өлгий	1144	1358	Сэлэнгэ	1067	1318
Баянхонгор	2199	2983	Төв	455	1072
Булган	263	2528	Увс	1384	2405
Говь-Алтай	987	1022	Ховд	636	1017
Дорноговь	346	515	Хөвсгөл	1923	2336
Дорнод	925	827	Хэнтий	1025	908
Дундговь	445	570	Дархан-Уул	1239	1715
Завхан	1683	1913	Орхон	1710	1887
Өвөрхангай	2407	2902	Говьсүмбэр	93	181
Өмнөговь	262	454	Нийт	22946	31125

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. 2009. 11 дүгээр сарын статистикийн мэдээлэл.